



Building a better  
working world

## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компанийн хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компани (хамтад нь "Групп" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлантай тохирч байна.

### Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Группийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг орлохгүй.

### Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх хэсэг багтсан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Харилцагчдад олгосон зээл болон урьдчилганы үнэ цэнийн бууралт" байсан.

### Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группийн удирдлагын хариуцлага юм.


### Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн Хураангуй Тайлангийн Талаар Дүгнэлт Өгөх Гэрээт Ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

*Ernst & Young Mongolia Audit LLC*

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан

  
Мандахбаяр Доржбат  
Захирал

Баталсан

  
Адриан Чу  
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс  
Огноо: 2021 оны 2 дугаар сарын 5

**ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компани  
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн  
Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан**

	<b>2020</b> мян.төг	<b>2019</b> мян.төг
Хүү, түүнтэй адилтгах орлого	16,377,802	18,321,082
Хүүний зардал	(4,723,510)	(4,654,241)
<b>Хүү, түүнтэй адилтгах цэвэр орлого</b>	<b>11,654,292</b>	<b>13,666,841</b>
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(2,360,681)	(1,618,802)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>9,293,611</b>	<b>12,048,039</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(5,738,460)	(5,565,125)
Бусад зардал	(799,670)	(451,539)
<b>Орлогын албан татварын өмнөх ашиг</b>	<b>2,755,481</b>	<b>6,031,375</b>
Орлогын албан татварын зардал	(323,288)	(1,121,186)
<b>Тайлант хугацааны цэвэр ашиг буюу хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>2,432,193</b>	<b>4,910,189</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>MNT</b>	<b>MNT</b>
Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг	3.06	6.16

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

**ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компани  
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан**

	<b>2020 оны 12 сарын 31 мян.төг</b>	<b>2019 оны 12 сарын 31 мян.төг</b>
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	10,348,101	2,382,196
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	25,430,960	49,457,676
Дериватив санхүүгийн хөрөнгө	-	130,642
Бусад хөрөнгө	3,274,193	4,571,315
Урьдчилж төлсөн төлбөр	5,650	-
Орлогын албан татварын авлага	92,699	-
	<b>39,151,603</b>	<b>56,541,829</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
Биет бус хөрөнгө	403,145	342,002
Үндсэн хөрөнгө	537,256	385,882
Ашиглах эрхтэй хөрөнгө	573,727	776,219
Хойшлогдсон татварын хөрөнгө	54,152	48,186
Урьдчилж төлсөн төлбөр	15,577	6,835
	<b>1,583,857</b>	<b>1,559,124</b>
	<b>40,735,460</b>	<b>58,100,953</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Зээллэг	19,424,810	32,475,285
Түрээсийн өр төлбөр	203,766	170,427
Бусад өр төлбөр	1,082,163	1,297,090
Дериватив санхүүгийн өр төлбөр	124,549	-
Орлогын албан татварын өглөг	18,913	151,395
	<b>20,854,201</b>	<b>34,094,197</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Зээллэг	1,690,790	6,104,737
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	23,124
Түрээсийн өр төлбөр	476,651	680,417
	<b>2,167,441</b>	<b>6,808,278</b>
	<b>23,021,642</b>	<b>40,902,475</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Хувьцаат капитал	10,756,859	10,756,859
Халаасны хувьцаа	(988,939)	(266,086)
Бусад сан	57,348	57,348
Хуримтлагдсан ашиг	7,888,550	6,650,357
	<b>17,713,818</b>	<b>17,198,478</b>
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>40,735,460</b>	<b>58,100,953</b>

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.